



**ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН
ДАРГА-ЕРӨНХИЙ ЭМЧИЙН
ТУШААЛ**

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар A/460

Улаанбаатар хот

**Цус сэлбэлтийг зохицуулах салбар
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Донорын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/256 дугаар тушаал, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.5.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар, Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн гишүүдийн болон цусны нөөц зохицуулах нэгжийн ажил үүргийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг клиникийн захирлууд, тасгийн дарга, эмч, мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба болон Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлд тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Цэргийн төв эмнэлгийн дарга ерөнхий эмчийн 2022 оны А/205 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА-ЕРӨНХИЙ ЭМЧ
ХУРАНДАА Б.ЭНХ-ОД



Цэргийн төв эмнэлгийн дарга-
ерөнхий эмчийн 2024 оны 10
дүгээр сарын 02-ны өдрийн А/НБ0
дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт 1117138660
УКВ0050 9095764

ЦУС СЭЛБЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөл /цаашид ЦСЗСЗ гэх/ нь эмнэлгийн хэмжээнд донорын цус, цусан бүтээгдэхүүн сэлбэлтийн үйл ажиллагааг зохицуулах, аюулгүй байдлыг мөрдөн ажиллахад хяналт тавих, болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрх зүйн холбогдох актыг мөрдөх, бодлого төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах үүрэгтэй ажиллана.

1.2 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал, байнгын ба төлөвлөгөөт хяналт, гишүүдийн идэвхтэй үйл ажиллагаа байна.

ХОЁР. Удирдлага зохион байгуулалт:

2.1 Цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг Эмнэлгийн дарга ерөнхий эмчийн тушаалаар томилж, батална.

2.2 Зөвлөл нь холбогдох хууль, журмын хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулан хэрэгжүүлж, цус цусан бүтээгдэхүүний хэрэглээнд хяналт тавьж ажиллана.

2.3 Эмнэлзүйн трансфузиологич эмч нь эмнэлгийн өдөр тутмын тусламж үйлчилгээнд эмнэлгийн хэмжээнд хэрэглэж буй цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, эмнэлзүйн байдал, эмчилгээний заалтын үндэслэл зэрэгт хяналт тавих, эмнэлзүйн эмч нартай хамтран шийдвэр гаргах зэрэг үйл явцад оролцож ажиллана.

ГУРАВ. Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаа:

3.1 Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл нь дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үйл ажиллагаатай холбоотой батлагдсан удирдамж, заавар, стандарт, үйл ажиллагааны журмыг эмнэлгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллахад удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.

3.1.2 Эмнэлгийн тусламж үйлчилгээнд цус сэлбэх аюулгүй ажиллагааны стандартын мөрдөлт, батлагдсан журмын хэрэгжилтийг хангуулж ажиллана.

3.1.3 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийг бүртгэж шалтгааныг тогтоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

3.1.4 Цус цусан бүтээгдэхүүний захиалга, тээвэрлэлт, хадгалалт, сэлбэлт, хангамжийн байдалд төлөвлөгөөт хяналтыг улирал бүр хийнэ.

3.1.5 Цус цусан бүтээгдэхүүний хэрэглээний байдалд судалгаа хийж хагас жил тутам тайлагнаж цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээг хэвшүүлэхэд идэвх санаачилгатай ажиллана.

3.1.6 Цус цусан бүтээгдэхүүн, цус орлох бэлдмэлүүдийн чанар, хангамж, нийцэл эмчилгээний үр дүнд хяналт тавьж цус цусан бүтээгдэхүүний хэрэглээний

байдалд судалгаа хийж хагас жил тутам тайлагнана. Тайлангийн дүнд үндэслэн зорилтот үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулна.

3.1.7 Эмнэлгийн эмч, ажилчид аюулгүй цус сэлбэлт цусны донорын сэрэмжийн үйл ажиллагааны талаар мэргэжил арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулж үр дүнг тооцож ажиллана.

Цэргийн төв эмнэлгийн дарга-
ерөнхий эмчийн 2024 оны 10
дүгээр сарын 02-ны өдрийн А/460
дугаар тушаалын гуравдугаар
хавсралт 1117138660
УКВ0050 9095764

ДӨРӨВ. ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Зөвлөлийн даргын эрх үүрэг;

4.1.1 Зөвлөлийн дарга нь зөвлөлийг удирдан, зохион байгуулалтаар ханган ажиллана.

4.1.2 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үйл ажиллагаатай холбоотой тулгамдсан асуудлыг шийдэх, холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.3 Зонхилон тохиолдох өвчний үе дэх цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээний удирдамжийг хэрэгжүүлж ажиллахад чиглэл өгнө.

4.1.4 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох тодорхой асуудлаар зөвлөлийн гишүүдтэй хамтран зөвлөмж шийдвэр гаргаж эмнэлгийн захиргаанд уламжлан тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ.

4.1.5 Цус цусан бүтээгдэхүүн, цус орлох бэлдмэлүүдийн аюулгүй байдал, хэрэгцээ сонор сэрэмжийн байдал, эмчилгээний үр дүн, зохистой хэрэглээг хэвшүүлэхтэй холбоотой асуудлаар санал дэвшүүлэх, зөвлөмж өгч ажиллана.

4.1.6 Зөвлөлийн гишүүдийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтад хамруулах талаар удирдлагад санал оруулах эрхтэй.

4.2 Зөвлөлийн нарийн бичиг, трансфузиологич эмчийн эрх үүрэг;

4.2.1 Нарийн бичиг нь зөвлөлийн даргын удирдлагад үйл ажиллагаа явуулах бөгөөд эмнэлгийн цус цусан бүтээгдэхүүний өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулалтаар ханган, зөвлөмж чиглэл өгч ажиллана.

4.2.2 Салбар зөвлөлийн хурлын тов тогтоож, хурал зохион байгуулж хурлын тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөлийн даргад асуудал дэвшүүлж шийдвэр гаргахад санаачилгатай ажиллана.

4.2.3 Хагас болон бүтэн жилийн тайланг нэгтгэж зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

4.2.4 Цус трансфузиологич эмч нь цусны сонор сэрэмжийн талаарх үйл ажиллагааг бүхэлд нь хариуцан ажиллана.

4.2.5 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх батлагдсан, зохистой аргуудыг нэвтрүүлэх, цус орлох шингэн бусад бэлдмэлүүдийн хэрэглээг дэмжих хэрэгцээт бүтээгдэхүүний хангамж, олгогдоогүй бүтээгдэхүүний хэмжээг нэр төрлөөр нь тооцон шалтгааныг тогтоох, хүртээмжийг сайжруулах, шаардлагагүй сэлбэлтийг бууруулах ажлыг зохион байгуулж ажиллана.

4.2.6 Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай цус цусан бүтээгдэхүүний хэрэгцээг тасаг, нэгж бүрээр жил улирал, сараар тооцон гаргаж өмнөх сар, улирал, жилийн хэрэглээтэй харьцуулан тооцож дүгнэлт хийж тайлагнана. Тайланд үндэслэн

үйл ажиллагааг зөв зохистой, үр дүнтэй сайжруулах ажил санаачлан хийж хэрэгжүүлнэ.

4.2.7 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлтийн чанарын судалгааг тогтмол зохион байгуулж, тасаг нэгжүүдийг мэдээллээр хангаж, зохион хэрэглээг төлөвшүүлэх ажлыг хариуцан ажиллана.

4.2.8 Эмнэлгийн цус цусан бүтээгдэхүүний хангалт, цус цусан бүтээгдэхүүн сэлбэх заалт, хэрэглээний байдалд хүйтэн хэлхээний горимыг мөрдөн ажиллаж буй байдал, үр дүнд хяналт тавьж ажиллана.

4.2.9 Илэрсэн урвал, хүндрэл бүрийг бүртгэн шалтгааныг тодруулан эмнэлгийн цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл ба цус сэлбэлт судлалын үндэсний төвд мэдээлж сэлбэлттэй холбоотой холбогдох мэдээлэл, лабораторийн хариу, цусны сорьц, сэлбэсэн бүтээгдэхүүний үлдэгдлийг хүргүүлэх, шалтгааныг тогтоох, хүндрэлээс сэргийлж ажиллана.

4.2.10 Хугацаа дууссан, дахин хэрэглэж боломжгүй цус цусан бүтээгдэхүүн гарахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг ханган ажиллаж, гарсан тохиолдолд шалтгааныг нөөцийн сувилагчийн хамт тогтоон цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийн бичгийн даргад танилцуулан устгал хяналтыг эмэн эмчилгээг зохицуулах хорооны хурлаар хэлэлцүүлэн, холбогдох журмын дагуу устгаж тэмдэглэл хөтөлж баримтжуулан ажиллана.

4.3 Эмчилгээ үйлчилгээний чанарын хяналтын албаны эрх үүрэг;

4.3.1 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үйл ажиллагаатай холбоотой стандарт ажиллагааны аргачлалуудыг эмнэлгийн хэмжээнд хэрэгжүүлж буй байдалд хяналт тавьж ажиллах ба мөрдүүлж ажиллахад шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

4.3.2 Цус цусан бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, хэрэглээ хангамжийн байдалд удирдамжид төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус үзлэг, хяналт хийх, илэрсэн доголдол, дутагдлыг арилгуулах ажлыг шуурхай зохион байгуулж, болзошгүй эрсдэлээс сэргийлэн эргэн хяналт хийж, мэдээллээр хангана.

4.3.3 Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар эрүүл мэндийн мэргэжилтний сургалт зохион байгуулна.

4.3.4 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой хөтлөгдөх эмнэлгийн анхан шатны маягт хөтлөлт стандарт, журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

4.4 Лабораторийн тасгийн эрх үүрэг;

4.4.1 Үйлчлүүлэгчийн цусны бүлэг, цус цусан бүтээгдэхүүний хувийн тохироог тодорхойлох ажлыг удирдан зохион байгуулж чанар аюулгүй байдлыг хангаж ажиллана.

4.4.2 Цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээний үр дүн, үл тохирол гарсан тохиолдолд клиник лабораторийн шинжилгээгээр хянан хэлэлцүүлэг зохион байгуулж зөвлөлд танилцуулан ажиллана.

4.4.3 Цус цусан бүтээгдэхүүний үл тохирол гарсан тохиолдолд трансфузиологич эмчид мэдээлж холбогдох арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

4.4.4 Цусны бүлэг, цус цусан бүтээгдэхүүний хувийн тохироо үзэх арга, аргачлалын талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулна.

4.5 Эмзүйн албаны эрх, үүрэг;

4.5.1 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой альтернатив аргад хамаарах цус орлох шингэний нөөцийг бүрдүүлж хангалт хэрэглээнд хяналт тавьж ажиллана.

4.5.2 Донорын хөдөлгөөнийг дэмжих талаар хамтран ажиллана.

4.5.3 Хэрэглэгдээгүй, хугацаа нь дууссан, хэрэглэх боломжгүй цус цусан бүтээгдэхүүний хэрэглээгүй шалтгааныг тодруулан, өртгийг тооцож зөвлөлөөр хэлэлцүүлэх үүрэг хүлээж ажиллана.

4.5.4 Цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээний талаар сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

4.6 Сувилахуйн албаны үүрэг;

4.6.1 Цус цусан бүтээгдэхүүний зохицуулалт хариуцсан сувилагчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэгт хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

4.6.2 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, тусламж, үйлчилгээний чанарын асуудлаар сувилахуйн үйл ажиллагаанд илэрч буй доголдол зөрчлийг арилгах ажлыг шуурхай зохион байгуулан ажиллана.

4.6.3 Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үйл ажиллагаатай холбоотой сургалт, сурталчилгааны ажлыг трансфузиологич эмчтэй хамтран зохион байгуулна.

4.6.4 Сувилагч мэргэжилтнүүдийг эрсдэлд өртөхөөс сэргийлэх, өртсөн тохиолдолд хариу арга хэмжээ авах арга барил, дадал эзэмшүүлэх сургалт зохион байгуулан ажиллана.

4.7 Цусны нөөцийн сувилагчийн үүрэг;

4.7.1 Цус цусан бүтээгдэхүүний нөөцийн бэлэн байдлыг хангаж өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

4.7.2 Цус цусан бүтээгдэхүүний захиалгыг хүлээн авах, нэгтгэн захиалах бүтээгдэхүүн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэлтийг хариуцах ба тасаг нэгж хүйтэн хэлхээний горимыг мөрдөн ажиллаж буй өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

4.7.3 Цус цусан бүтээгдэхүүний хэрэглээний анхан шатны маягыг зааврын дагуу хөтөлж хэвшсэн байх бөгөөд тасаг нэгжийн цус цусан бүтээгдэхүүний анхан шатны бичиг баримтын хөтлөлтөд хяналт тавьж, зөвлөгөө өгч, мөрдлөг болгуулж ажиллана.

4.7.4 Хэрэглэсэн цус цусан бүтээгдэхүүний сав баглаа боодол, устгалын байдалд хяналт тавина. Үргүй зардлыг тооцоход дэмжлэг үзүүлж ажиллана.

4.7.5 Хугацаа дууссан, дахин хэрэглэх боломжгүй цус цусан бүтээгдэхүүн гаргахгүй байх талаар идэвх санаачилгатай ажиллах, гарсан тохиолдолд шалтгаан, буруутай этгээдийг олж тогтоон трансфузиологич эмчид мэдэгдэж ажиллана.

4.8 Нэгжийн эрх, үүрэг;

4.8.1 Тасгаас ирүүлсэн цус, цусан бүтээгдэхүүний захиалгыг авч нэгтгэн, цус сэлбэлт судлалын үндэсний төвд илгээнэ.

4.8.2 Цус, цусан бүтээгдэхүүнийг хүйтэн хэлхээний зөв нөхцөлд тээвэрлэнэ.

4.8.3 Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээтэй уялдуулан 7 хүртэл хоногийн нөөц бүрдүүлэн, нөхөн хангалт хийнэ.

4.8.4 Нөөцийн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдал, хадгалалтын явц дахь хяналтыг хариуцсан эмч, тусгай мэргэжилтэн хариуцна.

4.8.5 Хувийн тохироо тодорхойлох бүтээгдэхүүний гээг гуурсыг авч лабораторид илгээн, тохирсон бүтээгдэхүүнийг зөв өвчтөнд олгоно.

4.8.6 Цус, цусан бүтээгдэхүүн хадгалж байгаа хөргөгч, хөлдөөгчний хэмийг хоногт 3 удаа хянаж баримтжуулна.

4.8.7 Захиалга авах, хүргүүлэх, тээвэрлэх, эмнэлэгт хадгалах, бүтээгдэхүүний дээжийг өвчтөний сорьцтой хамт лабораторид зөөвөрлөх, тасаг нэгжүүдэд олгох, нөөцийг зохицуулах, сэлбэсэн бүтээгдэхүүнийг бүртгэх үйл ажиллагааг бүрэн баримтжуулж архивлана.

4.8.8 Бүлэг, хувийн тохироо тодорхойлох, урвал хүндрэл илэрсэн тохиолдолд лавлагаа шинжилгээнд илгээх сорьцыг зөв авч тээвэрлэн ЦССҮТөвд хүргүүлэн холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.8.9 Цус, цусан бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалттай холбоотой тулгамдсан асуудлыг эмнэлгийн удирдлагаар шийдвэрлүүлнэ.

Тав. Хариуцлага:

5.1 Мэргэжлийн үйл ажиллагааны стандартуудыг мөрдөн ажиллаж энэхүү журам болон түүнтэй холбогдон гарсан тушаалыг нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд мөрдлөг болгон ажиллах ба зөрчсөн тохиолдолд холбогдох журам, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.2 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ зөрчигдсэн тохиолдолд Эмнэлгийн ёс зүйн салбар хороонд шилжүүлнэ.

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ